

# Экоминерал ХХК

БАРИЛГА УГСРАЛТ, ГАДНА ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ

2015  
ENTREPRENEUR



БАРИЛГА УГСРАЛТ,  
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ



АВТО ЗАМ, ЗАМЫН  
БАЙГУУЛАМЖ



БАРИЛГЫН ГАДНА ИЖ  
БҮРЭН ТОХИЖИЛТ,  
ЗУРАГ ТӨСӨЛ



НОГООН  
БАЙГУУЛАМЖ,  
УСАЛГААНЫ СИСТЕМ



БЕТОН ХИЙЦИЙН  
ЧАНАР САЙЖРУУЛАХ  
ШИЙДЭЛ



БЕТОН ХИЙЦИЙГ  
УС ЧИЙГНЭЭС  
ТУСГААРЛАХ ШИЙДЭЛ



БИДНИЙ ШИЙДЭЛ, ТУРШЛАГА, ГАДААД ХАМТРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨ  
ТАНАЙ ТӨСЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ ГЭДЭГТ ИТГЭЛТЭЙ БАЙНА

“Экоминерал” ХХК 2007 онд уул уурхайн нөхөн сэргээлтийн чиглэлээр байгуулагдсан бөгөөд энэ хугацаанд байгаль орчны мониторинг, барилга угсралтын ажил, барилгын гадна тохижилтын зураг төсөл боловсруулалт, иж бүрэн гүйцэтгэл, авто зам, замын байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөсөн.

**Худалдааны чиглэлээр** бетон хийцийн чанар сайжруулах шийдэл болох ADFIL /Англи/, бетон хийцийг ус чийгнээс тусгаарлах BONAR /Герман/, Усалгааны системийн MRain /АНУ/, DAYU /БНХАУ/ зэрэг дэлхийн шилдэг брэндүүдийг Монгол улсад худалдаалах албан ёсны борлуулагчаар, гадна тохижилтын **зураг төсөл, шийдлийн чиглэлээр** БНХАУ-ын Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна.

Манай гадаад мэргэжилтнүүдийн зөвлөгөө, шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүнүүд, бидний туршлага танай төслийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

## ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ

### 2011 он

Уул уурхайн нөхөн сэргээлт, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж нийт 250 га талбайд нөхөн сэргээлт гүйцэтгэв



### 2013 он

Тохижилтыг зураг, төсөл, усалгаа, гэрэлтүүлэг, тоглоомын талбай бүхий цогц үйлчилгээ үзүүлж эхлэв.



### 2015 он

Барилга угсралт, авто замын чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөж цутгамал өрөгт бүтээцэн барилгын гүйцэтгэл, 2.8 км хатуу хучилттай авто замын ажил гүйцэтгэв.



### 2012 он

Барилгын гадна тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөж 4 хотхоны тохижилтын ажил гүйцэтгэв.

### 2014 он

ADFIL, BONAR, DAYU, MRain брэндүүдийн дэвшилтэт технологи, шийдлийг Монголдоо нэвтрүүлэв.

### 2016 он

Гадаад хамтрагчийн оролцоотойгоор жишиг ногоон байгууламж бүхий хорооллын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



Барилгын цутгамал болон угсармал төмөр бетон бүтээцэн ажил /1-9 давхар хүртэл/



Услалтын системийн гидротехникийн барилга байгууламж



Хатуу хучилттай болон хучилтгүй, хайрган хучилттай зам барих /15 км хүртэл/



Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэг



### ЗУРАГ ТӨСӨВ, ЗӨВЛӨГӨӨ

- Гадна тохижилт, ландшафтын 3D, ажлын зураг төсөл, гүйцэтгэлийн төсөв
- Усан байгууламж, усалгааны систем, мод, бут, зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн шийдэл, зураг төсөл
- Газар доорх байгууламж, авто зогсоолын дээвэр дээрх ногоон байгууламжийн шийдлийн зөвлөгөө
- Гадна тохижилтын төлөвлөлт, талбай ашиглалт, дизайн шийдлийн зөвлөгөө

### БАРИЛГА УГСРАЛТ

- Цутгамал болон угсармал төмөр бетон, арагт бүтээцэн барилга
- Дотор, гадна гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиоллын систем
- Дотор усан хангамж, халаалт, хөргөлт, гадна салбар шугам сүлжээ
- Услалтын уст цэг, услалтын системийн гидротехникийн ажил
- Барилгын бүх төрлийн засал



### ЗАМ, ГАДНА ТОХИЖИЛТ

- Хатуу хучилттай цемент бетон, асфальтан, байгалийн чулуун зам, талбай
- Хайрган, дайрган, сайжруулсан шороон зам, талбай
- Гадна тохижилтын ажлын цогц гүйцэтгэл, арчилгаа
- Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай,
- Усан байгууламж, усжуулалтын систем

### ХУДАЛДАА

- Мананцар, бороожуулагч, дуслын усалгааны систем, дагалдах хэрэгсэл
- Гудамж, талбай, ногоон байгууламжийн гэрэлтүүлгийн хэрэгсэл
- Гадна талбайн иж бүрэн тоглоом, фитнесийн хэрэгсэл, резинэн шал
- Модны үрсэлгээ, суулгац, зүлэгний үр
- Бетон хийцийн чанар сайжруулагч, ус чийгнээс тусгаарлагч бүтээгдэхүүн



## ГҮЙЦЭТГЭСЭН БОЛОН ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД

### ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД



"БУМАН ӨЛЗИЙ" ХОРООЛОЛ

#### "БУМАН ӨЛЗИЙ" ХОРООЛОЛ

СХД, Орбитын эцэст байрлалтай 50% ногоон байгууламжтай, нийт 7 га талбайд 16 блок барилга, 200 машины эко зогсоол бүхий хороолол

**Захиалагч:** "Ти Си Ди" ХХК

**Ашиглалтанд орсон:** 2015 он

**Ажлын хүрээ:** Авто зам, зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



### ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД



ДӨЛ ХОТХОН

#### ДӨЛ ХОТХОН

ХУД, Улаанбаатар сувиллын урд байрлалтай 40% ногоон байгууламж бүхий 6 блок 426 айлын орон сууцны хотхон

**Захиалагч:** "Дөл импекс" ХХК

**Ашиглалтанд орсон:** 2015 он

**Ажлын хүрээ:** Авто зам, зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



### ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД

#### "ЦАГААН ХУАРАН" ХОРООЛОЛ

Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй БЗД, 14 хороонд байрлах 5 хэсэг блок бүхий 2248 айлын орон сууц, цэцэрлэг, худалдааны төвийн цогцолбор хорооллын төсөл

**Захиалагч:** "Цагаан хуаран консалтинг" ХХК

**Ашиглалтанд орсон:** 2016 он

**Ажлын хүрээ:** Авто зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



"ЦАГААН ХУАРАН" ХОРООЛОЛ



### ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД

#### "ГВ" ҮЙЛЧИЛГЭЭ, ОРОН СУУЦ

БГД, 1 хороонд байрлах өөрийн авто замтай, 132 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга

**Захиалагч:** "Глобал бевериж" ХХК

**Ашиглалтанд орсон:** 2015 он

**Ажлын хүрээ:** Авто зам, зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



"ГВ" ҮЙЛЧИЛГЭЭ, ОРОН СУУЦ



ГҮЙЦЭТГЭСЭН БОЛОН  
ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД

ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД



"ИХ ЦОГЧИН ДУГАН" ЦОГЦОЛБОР

**ИХ ЦОГЧИН ДУГАН**

Гандантэгчинлэн хийдийн 1080 лам ном хурах, нийт 6300м2 талбайг эзлэх "Их цогчин дуган" цогцолбор байгууламж

**Захиалагч:** "Си Эйч Си" ХХК

**Ашиглалтанд орох:** 2016 он

**Ажлын хүрээ:** Авто зам, зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД



"ENGLISH MANSION" ХОРООЛОЛ

**"ENGLISH MANSION" ХОРООЛОЛ**

ХУД, "Japan town" хотхонд байрлалтай Англи загварын интерьер, ландшафт бүхий 370 айлын орон сууц, үйлчилгээний төвтэй нийт 7 га талбайд хэрэгжиж буй төсөл

**Захиалагч:** "Mongol corporation" LLC

**Ашиглалтанд орох:** 2016 он

**Ажлын хүрээ:** Гадна тохижилт, ландшафтын зураг төсөл боловсруулалт, үзүүлэнгийн талбай, хорооллын иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД

**"ХАНГАЙ" ХОРООЛОЛ**

Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй СБД, 11 хороонд байрлах нийт 57 га талбайг хамрах 15000 айлын орон сууц, сургууль, цэцэрлэгийн цогцолбор хорооллын төсөл

**Захиалагч:** "Бэрэн групп" ХХК

**Ашиглалтанд орох:** 2016 он

**Ажлын хүрээ:** Авто зам, зогсоол, явган хүний зам, талбай, иж бүрэн гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч



"ХАНГАЙ" ХОРООЛОЛ



**"ASEM VILLAGE" ХОТХОН**


Хан-Уул дүүрэг, Хүрхрэн аманд байрлах 53 ширхэг Villa амины орон сууц болон Club house үйлчилгээний цогцолбороос бүрдэх төсөл

**Захиалагч:** "MSC Property" LLC

**Ашиглалтанд орох:** 2016 он

**Ажлын хүрээ:** 10\*20\*8см хэмжээтэй Голланд хавтангаар төв авто замаас хаусруу орох авто зам, хотхоны явган хүний замын ажлын гүйцэтгэл

ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ТӨСЛҮҮД



"ASEM VILLAGE" ХОТХОН



АВТО ЗАМ,  
ЗАМЫН БАЙГУУЛАМЖ

“Экоминерал” ХХК нь хатуу хучилттай /цемент бетон, асфальт бетон, хөнгөвчилсөн хучилт, замын ус зайлуулах байгууламж/, хучилтгүй зам /хайрган, дайрган, сайжруулсан шороон зам, хатуу хучилттай замын далан, суурийн ажил/ болон өөрийн машин механизмыг ашиглан суурийн газар шорооны ажлуудыг гүйцэтгэж байна.

ADFIL брэндийн ган болон нийлэг утсан бүтээгдэхүүнүүдийг бетон хийцэд хольж хэрэглэснээр бүтээц эдлэлийн бат бөх байдлыг сайжруулж шахалт суналтаас үүсэх хэв, гажилтыг багасгах, галд тэсвэртэй байдал, үрэлтэд тэсвэртэй чанарыг өсгөж, эсэргүүцэл, хүйтэнд тэсвэрлэлт болон ус, химийн бодист өртөх нөлөөллийг бууруулдагаараа дэлхийд танигдсан дэвшилтэт технологи юм.

/Дэлгэрэнгүй мэдээллийг [www.adfil.co.uk/](http://www.adfil.co.uk/)

ГАЛД ТЭСВЭРТЭЙ НИЙЛЭГ УТАС (IGNIS®)

Бетон хийцэнд полипропилен төрлийн нийлэг утас нэмж хийснээр халалтаас үүсэх нүхэн дэх даралт, суналтыг бууруулж галд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлдэг.


Авто замын болон төмөр замын туннель, барилгын бетон цутгамал хийц, кабелин туннель, гүүр, далд уурхай болон олон давхар авто граж, галд тэсвэрлэх бусад бүтээгдэхүүнүүдэд хийхэд тохиромжтой.



АСФАЛЬТ БЕТОН ЗАМ

2015 он. “Глобал бевеиж” ХХК-ний орон сууцны барилгын асфальтбетон хучилттай 500 метр авто зам, борооны ус зайлуулах шугам хоолойн ажил,

2015 он. Гандантэгчинлэн хийдийн “Их цогчин дуган” цогцолбор байгууламжийн гаднах суурь үе 4см, өнгө үе 3см асфальт бетон хучилттай авто зам, зогсоолын ажил,



ГАН УТАС (STEEL FIBRES®)

Төрөл бүрийн хэлбэр хэмжээтэй ган утсыг бетон зуурмагт хольсноор суналтын бат бэх, уян хатан чанарыг нэмэгдүүлж, агшилт тэлэлтийн ан цавыг багасгадаг. Үйлдвэрийн шал, туннель, галд тэсвэртэй бүтээгдэхүүн, угсармал болон цутгамал бетон бүтээц хийхэд тохиромжтой.

МОНФИЛАМЕНТ УТАС (MONFILAMENT FIBRES®)

Монфиламент нийлэг утас нь бетон хийцийн хүйтэнд тэсвэрлэх болон ус, химийн бодист өртөх нөлөөллийг бууруулж бат бэх байдал, гадаргуугийн шинж чанарыг сайжруулдаг. Гадна зогсоол, цутгамал барилга, дотор шал, бетон дүүргэлт, туннель, ус зайлуулах хийцэд хэрэглэхэд тохиромжтой.



ЦУТГАМАЛ БЕТОН ЗАМ

2012 он. “Танан импекс” ХХК-ний авто граж, сервесийн зориулалттай барилгын гаднах хүнд даацын автомашин зорчих арматураар хүчитгэсэн 20см бетон хучилттай 4700м<sup>2</sup> авто зам талбайн ажил,

2015 он. “Ай Пи Эс Эс” ХХК-ний орон сууцны хотхоны бетон зам, байрууд дундах гражны дээвэр дээрх 1050м<sup>2</sup> цутгамал бетон авто зогсоолын ажил,



МАКРО НИЙЛЭГ УТАС (DURUS)

DURUS нийлэг утсыг бетон зуурмагруу шууд хийснээр төмөр арматурын ажлыг бүрэн орлож, бага зардлаар эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалтыг хангасан эдийн засгийн өндөр үр ашигтай ажлыг гүйцэтгэх боломжтой болдог. Угсармал болон цутгамал бетон хийц дам нуруу, хоолой, ус цэвэршүүлэх болон хадгалах байгууламж хийхэд ашиглахад тохиромжтой.

БАЙГАЛИЙН ЧУЛУУН ЗАМ

2015 он. ХУД, “English mansion” хорооллын үзүүлэнгийн талбайн 920м<sup>2</sup> авто зогсоолыг элэгдэл багатай, дахин ашиглах боломжтой байгалийн 10\*10см харьцаатай боржин чулуун хавтангаар тавих ажил,

2015 он. БГД, төмөр замд төв замуудыг байрнуудын дундуур холбосон 230 метр урттай, байгалийн боржин чулуун туслах авто замын ажил,



ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОМЖУУД

Бүх төрлийн бетон хийцийн чанарыг сайжруулах, эдэлгээг уртасгах, ус, галд тэсвэртэй чанарыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашигтайгаар ажлыг гүйцэтгэх зорилгоор дэлхийн 60 гаруй оронд ашигладаг.



БЕТОН ХИЙЦИЙГ УС ЧИЙГНЭЭС  
ТУСГААРЛАХ ШИЙДЭЛ



Дэлхийн 60 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулдаг, салбартаа тэргүүлэгч Bonar корпорацийн инженерийн барилга байгууламжид зориулсан бетон хийцийг ус, чийгнээс тусгаарлах, хөрсний усыг гадагшлуулах, хөрс тогтворжуулах зориулалттай өндөр чанарын синтетик нэхээсгүй бүтээгдэхүүн болох Enkammat, Enkadrain, Enkagrid, Colbondrain бүтээгдэхүүнүүдийг албан ёсны эрхтэйгээр Монголын зах зээлд нэвтрүүлж байна.


/Дэлгэрэнгүй мэдээллийг [www.colbond-geosynthetics.com/](http://www.colbond-geosynthetics.com/)

**Enkadrain®**

Барилгын суурь бүтэц, бусад инженерийн байгууламжуудыг барих үед болон ашиглалтад оруулсны дараах эвдрэлийн 70% нь уснаас үүдэлтэй байдаг.

Энэхүү асуудлыг Enkadrain буюу бетон хийцийг хөрсний болон гадаргын ус чийгээс хамгаалах зориулалттай хийгдсэн синтетик гадаргуутай бүтээгдэхүүнийг ашиглан шийдсэнээр богино хугацаанд эдэлгээ урттай инженерийн байгууламжийг барих бололцоог олгодог.

Enkadrain нь нэвчилтийн чанар, ус зайлуулах чадвар, уян хатан-хөнгөн байдал, хялбар угсрагдах байдал, хөрсөнд үзүүлэх биологийн болон химийн нөлөөлөл, галд тэсвэртэй байдал зэрэг үзүүлэлтээрээ Евро стандартыг хангадаг.



COLBOND



**Enkagrid®**

**Enkagrid нь бетон хийцэн талбай, авто зам, суурийн хөрсийг сайжруулах зориулалттай, хөрс хуулалт, шинээр суурь үүсгэх ажлыг хөнгөвчилж дээрээс ирэх даралтыг хэвтээ чиглэлд жигд тарааж хэв гажилтад орохоос хамгаалдаг бүтээгдэхүүн.**

Барилга байгууламжийн газар шорооны ажлын техник, хүн хүч, цаг хугацааг хэмнэж бага зардлаар өндөр үр дүнтэйгээр хөрсийг тогтворжуулах, бэхжүүлэх оновчтой шийдэл юм.



**Enkammat®**

Барилгын ажлын дараа эвдэрсэн хөрс, байгалийн бусад налуу эргийг нөхөн сэргээх, хэвийн байдалд нь оруулах зайлшгүй шаардлага гардаг. Налуу гадаргуу дээрх өвсний үр, суулгац, шимт хөрсийг салхи болон усны үйлчлэлээр урсгахгүй байлгах, хамгаалах суурь бий болгох зориулалттай Enkammat материалыг шууд дэвсэж хэрэглэдэг.


Enkammat нь хөрс, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэггүй бөгөөд ургамлыг хөрсөнд бүрэн бэхэжсэний дараа уусаж алга болдог онцлогтой.



**Colbondrain®**

Инженерийн барилга байгууламжийн суурь бэлдэхэд хөрсний үзүүлэлтээс шалтгаалж хөрс хуулалт, тээвэрлэлт, боловсруулалтад ихээхэн хэмжээний хөрөнгө, цаг хугацаа зарцуулаад зогсохгүй хөрс их хэмжээгээр эвдэх түүнийгээ нөхөн сэргээх шаардлага тулгардаг.

Энэ бүхнийг хялбар аргаар шийдсэн шинэ технологи Colbondrain нь хэвийн нөхцөлд 20-25 жилд нягтардаг үйл явцыг 6 сарын дотор хөрсний сийрэгжилт, чийгшлийг гадагшлуулж, хөрсийг 90% хүртэл нягтаршуулдаг.



## УСАЛГААНЫ СИСТЕМИЙН ХЭРЭГСЭЛ

Уур амьсгал, байгалийн олон янзын нөхцөл, хэрэглээнд тохирсон хагас болон бүрэн автомат удирдлагатай сүүлийн үеийн мананцар, бороожуулагч, дуслын усалгааны системүүдийн тоног төхөөрөмжийг газар тариалан, барилгын гадна ногоон байгууламжны усалгаанд зориулан БНХАУ-н DAYU, MRain компаниудаас шууд нийлүүлэхийн зэрэгцээ танай байгууламжийн усжуулалтын зураг, төсвийг гаргах, угсралт суурилуулалт хийх үйлчилгээ үзүүлж байна.

"Mini Rain Irrigation" LLC нь дуслын болон талбайн усалгааны системийн зөвлөгөө, шийдэл загварчлалын үйлчилгээ үзүүлдэг, бичил усжуулалтын системийн шинжилгээ судалгааг мэргэжлийн түвшинд хийж үйлдвэрлэлийн технологи боловсруулдаг зөвлөх үйлчилгээний компани юм.

"DAYU" LLC нь БНХАУ-н усалгааны системийн үйлдвэрлэлийн бизнесийн 35 хувийг эзэлдэг, дэлхийн 35 оронд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг усалгааны тоног төхөөрөмж, хэрэгсэл үйлдвэрлэдэг томоохон компани.

**Pop-Up Spray Heads** - хөрсөн доорх хоолойд холбогдон суурилж усны даралтаар цацруулагч хошуу нь шүрших түвшинд өргөгдөн 40°-аас 360°-ийн өнцөгт тохируулгаар жигд услах зориулалттай гадна ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэгддэг.

Pop-Up Spray Heads



**Impact Sprinkler** - 14 метр хүртэл зайд цагт 1-1,5 м³ усыг жигд цацруулж услах чадалтай түгээмэл хэрэглэгддэг цохилтод шүршигч усалгааны хэрэгсэл. Даралтаас шалтгаалж төмөр, хуванцар хийцтэй сонгох бололцоотой.

**Nozzle** - Хүлэмж доторх үрсэлгээ, суулгацыг жигд услахад тохиромжтой цацруулагч, өлгөгдөж байрлагддаг мананжуулагч хуванцар хошуунууд.

**Drip irrigation** - Дуслын усалгааны систем нь бордоот усыг хавхлага хоолой, хоолойд суурилуулсан дусласгийн тусламжтайгаар хөрсний гадаргуугаас эсвэл хөрсний гүнээс мод, таримал ургамлын үндсэнд аажмаар шингээх технологи. Хур бороо, усны гачааллаас хамаарахгүйгээр ургамлын үндэс байгаа хэсэгт усалгааг тогтоосон цагт хийж ургалтыг 2 дахин нэмэгдүүлж усыг 70 хувь хүртэл хэмнэж, ургацын хэмжээг 230 хувь хүртэл өсгөх боломжтой.

**Controller** - цаг уур орчны нөхцөл, ургамлын усалгааны технологиос шалтгаалан услалтын цаг, хэмжээг хагас болон бүрэн автомат байдлаар тохируулах бололцоог олгодог удирдлагын систем.



Drip irrigation



Controller

### ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХАВТАН

“Форвард блок констракшн” ХХК-д Герман улсын техник, технологиор өндөр даралтаар шахаж чанарын өндөр түвшинд үйлдвэрлэгдсэн төрөл бүрийн явган замын хавтан, блок, бордюр



### ГЭРЭЛТҮҮЛЭГ

Гудамж, талбай, ногоон байгууламжийн шинэлэг загвар шийдэлтэй, бүх төрлийн тэжээлийн эх үүсвэрээр ажилладаг, эрчим хүчний хэмнэлттэй ердийн болон лед гэрэлтүүлгийн хэрэгслэл



### БУСАД ХЭРЭГСЭЛ

Тухайн орчинд нийцсэн мод, хуванцар, төмөр, чулуун хийцэн өргөн сонголттой гудамжны сандал, хогийн сав, цэцгийн мандал гэх мэт хэрэгслүүд



### СҮҮДРЭВЧ

Амрах тав тухыг хангасан өнгө үзэмж, загварын олон шийдэлтэй үйлдвэрийн хатаалттай модоор хийгдсэн төрөл бүрийн сүүдрэвчүүд



### СПОРТ ТАЛБАЙ

Спортын чийрэгжүүлэлтийн талбайн иж бүрэн хэрэгслүүд /резинен шал, торон хашаа, сагсны самбар, фитнесийн хэрэгсэл/



### ХҮҮХДИЙН ТОГЛООМ

Хүүхдийн насны ангилалд тохирсон сонголттой, эрүүл аюулгүй хуванцар материалаар хийгдсэн 3-12 метрийн урттай, 1,5-5 метрийн өндөртэй тоглоомын иж бүрдэл







**Хаяг:** УБ хот, Баянгол дүүрэг, 4 хороо, Энхтайвны өргөн чөлөө, Луна плаза 602 тоот  
**Утас:** 76119599, 88039599, 94996599, 99909522  
**Вэб:** [www.ecomineral.mn](http://www.ecomineral.mn)  
**И-мэйл:** [contact@ecomeneral.mn](mailto:contact@ecomeneral.mn)